

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС 2022 ОНД БАТЛАН ГАРГАСАН ЗАХИРАМЖИЙН 2 ДУГААР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ
(Сайхан-Овоо суманд хамааралтай заалт)

2022.06.30

№	Захирамжийн дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Заалтын дугаар	Заалт	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт, үр дүн	Хувь
1	A/01	“Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарлах тухай 2022.01.05		4. “Хүний хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), 2022 оны ажлын төлөвлөгөөндөө зорилт арга хэмжээ тусган шаардагдах зардлын эх үүсвэрийг шийдвэрлэж ажиллахыг төрийн байгууллагын дарга, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Сумдын Засаг нар Төрийн байгууллагын дарга нар	Хүний хөгжлийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөө батлагдан ирээгүй тул төлөвлөлт хийгдээгүй ч Сайхан-Овоо сумын хэмжээнд 2022 оныг “Хувь хүний хөгжлийг дэмжих жил” болгон зорилт тавин ажиллаж 3 зорилтийн хүрээнд 25 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна.	70%
2	A/98	Электрон тамхи худалдан борлуулахыг хориглох тухай 2022.03.11		2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ЦГ МХГ Сумдын Засаг дарга нар	Сумын хэмжээнд электрон тамхи худалдан борлуулахгүй байхыг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдаалдаг 7 цэгт мэдэгдэж, ХАА-н тасгийн мэргэжилтэн Т.Ганбаатар болон цагдаагийн мөрдөгч Ш.Ууганбаяр нар хяналт тавин ажиллаж байна. 6-р сарын 30-ны байдлаар зөрчил илрээгүй байна. Захирамжийн хэрэгжилтийг 100% ханган ажиллаж байна.	100%

3	A/141	2022 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлага явуулах тухай 2022.04.06		2. 2022 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 04 дүгээр сарын 21-нээс 04 дугаар сарын 30-ны өдрүүдэд Дэрэн, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан сумдад зохион байгуулалтын өндөр түвшинд явуулсугай.	Сумдын Засаг дарга нарт	Хамаарахгүй	-
4	A/166	Үлийн цагаан оготной тэмцэх тухай 2022.04.14		1. Үлийн цагаан оготной энгийн механик аргаар тэмцэх ажлыг нийт сумдууд 2022 оны 05 дугаар сарын 05, 06-ны өдөр, 2022 оны 10 дугаар сарын 06,07-ны өдрүүдэд зохион байгуулсугай. 2. Засгийн газрын 185 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн мэргэжлийн анги албад, албан байгууллага, иргэд, малчдыг оролцуулан, хөдөлмөр хамгааллын хувцас, аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд мөрдүүлж ажиллах, уг арга хэмжээнд шаардагдах зардлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнөөс гаргахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ХХААГ дарга Сумдын Засаг дарга нар	Төгрөг багийн нутаг болох Сүүж, Модон, Дэлгэрэх гэх газруудад 14 малчин өрх, 24 иргэн 2000 га талбайд 6 утагч, 4 үлий цөмлөгч багажаар үлийн цагаан оготныг устгах ажлыг 2022 оны 05 дугаар сарын 05-наас 12-ны өдрийг хүртэл 7 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн.	100%
5	A/174	Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх		1. Малчид, мал бүхий иргэдэд мэдээлэл хүргэн, бэлэн байдлыг хангуулж гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтад үхэр	Сумдын Засаг дарга нарт	2022 оны 04 дүгээр сарын 25-ны А/32 дугаар захирамжаар шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 04 сарын 25-наас 05 сарын 15-ны	100%

		дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай 2022.04.20		сүргийг бүрэн хамруулах арга хэмжээг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан “Шүлхий дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах стандарт ажиллагааны заавар”-ыг баримтлан 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай. 4. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдрэмтгий мал, амьтны дархлаажуулалтын арга хэмжээг дуустал 2022 оны 05 дугаар сарын 15 өдрийг хүртэл хурдан морины уралдаан, отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнийг зогсоохыг сумын Засаг дарга нарт даалгасугай.		хооронд зохион байгуулж, хурдан морины уралдааныг хориглосон шийдвэр гарсан. Сумын хэмжээнд 4 багийн 2712 үхрийг хамруулж гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 100% хийж гүйцэтгэж, холбогдох материал болон тайланг хүргүүлж Мал эмнэлгийн нэгдсэн системд гүйцэтгэлийг хийж гүйцэтгэсэн.	
6	A/189	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай 2022.04.26		3. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, сумдын Засаг дарга нарт дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай. 3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу өөрийн байгууллагын эзэмшилд байгаа эд хөрөнгийн тооллогод хамруулах бэлтгэлийг хангаж, комисс, тооллогын ажлыг 2022 оны 06 дугаар сарын 15-ны дотор хийж гүйцэтгэх, 3.2. Төрийн цахим мэдээллийн санг ашиглан өөрийн байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаа газар, үл хөдлөх хөрөнгө, автотээврийн хэрэгслийн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах	Сумдын Засаг дарга нар	Сумын хэмжээнд Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах комиссыг сумын Засаг даргын А/44 тоот захирамжаар 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр томилж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа төсвийн 6 байгууллагад улсын үзлэг тооллогыг зохион байгуулах тухай мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч удирдамжаар ханган, байгууллага бүрт тооллогын комиссыг байгуулсан. Тус ажилтай хамтатган орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа үндсэн хөрөнгийг нүд үзэж тоолон, цахим санд бүртгэн баталгаажуулж, бүртгэл, эзэмшлийн зөрчилтэй зарим	100%

				3.3. Төв комисс, салбар комиссын удирдамж зааврын дагуу тооллогын дүн, тайланг бэлтгэн аймгийн Орон нутгийн өмчийн газрын ажлын хэсэг, төлөөлөгчид хянуулах, хүлээлгэн өгөх зохион байгуулалтын арга хэмжээг авах.		хөрөнгүүдийн зөрчлийг арилган, ашиглалтгүй болон илүүдэлтэй, худалдах, шилжүүлэх, акт тогтоох устгах үндсэн хөрөнгүүдийн талаар дүгнэлт тайлбарыг нэгтгэн гаргаж сумын өмч хамгаалах байнгын зөвлөлд уламжилж, тооллогын дүн мэдээг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгсөн.	
7	A/193	Хөдөө аж ахуйн ээлжит тооллого зохион байгуулах тухай 2022.04.29		4. Тооллогын ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулж, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өрх, аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулж, тооллогын ажилд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Сумдын Засаг дарга нарт	2022 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн А/48 дугаар захирамжаар Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, нийт 171 малчин өрх, тариаланч, аж ахуй нэгж байгууллагуудыг тооллогод хамруулсан. Тоологчоор Улсын бүртгэгч Ж.Энхжаргал, Найз багийн засаг дарга Б.Ган-Оргил нар ажиллаж, Төрийн сангийн мэргэжилтэн Ч.Түвшинбаяр тооллогын бүх материалыг цахимаар шалгаж, холбогдох байгууллагад дамжуулж гүйцэтгэсэн.	100%
8	A/194	Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай 2022.04.29		1. Дэлгэрхангай сумын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг “Ноён асралт” ХХК-ний XV-48000077(028/Ду), XV-48000079 (023/Ду), XV-48000078(024/Ду) дугаартай тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилийн хугацаагаар сунгасугай. 2. Тус аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Дэлгэрхангай сумын Засаг дарга (М.Батсүх) нарт тус тус үүрэг болгосугай.	МХГазар Ш.Төрбат Дэлгэрхангай сумын Засаг дарга	Хамаарахгүй	-

9	A/236	Архи, согтууруулах ундаа худалдах Түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрх олгох, сунгах тухай 2022.05.25	3. Гарсан шийдвэрийг холбогдох газарт хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар(Б.Мөнхбат), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ХОХБТХ ЦГ ТХ МХГ Сумдын Засаг дарга нар	Хамаарахгүй	-
Дүн	100%-5, 70%-1, 30%-, 0%-					95%

Хэрэгжилт тооцсон: ЗДТГ-ын хууль эрх зүйн мэргэжилтэн

Э.Отгонцэцэг

Хянасан: ЗДТГ-ын дарга

С.Болоржаргал